

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/023/НА-СТА-ТШЗ

Чингис хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар Утас: 70562112 Цахим хаяг: khentii@audit.gov.mn Аудитын менежер: Д.Оюунтуяа Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн Стандарт дүгнэлт аудит ХХК аудитор: Б.Наранцэцэг Утас: 99569960 Цахим хаяг: info@sda-audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2025.04.22 № 186

танай _____-ийн № _____ т

ХЭНТИЙ АЙМГИЙН ЦЭНХЭРМАНДАЛ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ОТГОНДУЛАМ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын төсвөөс 1,049,275.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 192,133.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 369.2 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 156.0 мянган төгрөг, нийт 1,241,934.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,136,283.1 мянган төгрөг зарцуулан, 1,868.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, харилцах дансандаа 209,483.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар 1,471.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд, 1 албан шаардлага хүргүүлээ.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

232502106

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 33 зорилтын хүрээнд 91 арга хэмжээ тусгагдаж, 88 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	168,418,210.15	297,592,661.64
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	103,832,030.68	209,483,454.47
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	103,832,030.68	209,483,454.47
3121	Төгрөг	103,832,030.68	209,483,454.47
31211	Төрийн сангийн харилцах	103,832,030.68	209,483,454.47
33	АВЛАГА	-	1.55
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага		1.55
35	БАРАА МАТЕРИАЛ	64,586,179.47	88,109,205.62
351	Түүхий эд материал	-	43,300.00
35130	Эм боох материал	-	43,300.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	240,000.00	2,658,200.00
354	Хангамжийн материал	63,881,179.47	85,197,705.62
35410	Бичиг хэргийн материал	403,580.00	227,080.00
35420	Аж ахуйн материал	6,622,300.00	4,692,500.00
35440	Түлш, шатах тослох материал	-	1,371,900.00
35450	Барилгын засварын материал		3,485,000.00
35460	Хүнсний материал	60,000.00	3,168,000.00
35470	Бусад хангамжийн материал	56,795,299.47	72,253,225.62
35600	Мал амьтад	465,000.00	210,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,927,822,345.34	2,120,748,822.03
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,927,822,345.34	2,120,748,822.03
392	Биет хөрөнгө	1,914,622,345.34	2,107,548,822.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,152,604,681.00	2,152,604,681.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(165,207,453.04)	(208,958,658.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	30,000,000.00	30,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(30,000,000.00)	(30,000,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	28,815,196.16	206,128,942.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(122,448,384.19)	(60,415,366.62)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	127,919,015.49	53,262,422.59
39208	Хуримтлагдсан элэгдэл	(107,060,710.08)	(35,073,198.66)
393	Биет бус хөрөнгө	13,200,000.00	13,200,000.00
39301	Програм хангамж	80,000.00	
39302	Хуримтлагдсан элэгдэл	(80,000.00)	
39303	Бусад биет бус хөрөнгө	13,200,000.00	13,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,096,240,555.49	2,418,341,483.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	77,913,916.00	56,664,664.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	77,913,916.00	56,664,664.00
413	Өглөг	77,913,916.00	56,664,664.00
4136	Бусад оглог	77,913,916.00	56,664,664.00
41361	Байгууллагад төлөх өглөг	77,913,916.00	56,664,664.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,277,663,439.49	2,361,676,819.67
51	Засгийн газрын хувь оролцоо	2,277,663,439.49	2,361,676,819.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,356,036,915.48	1,356,036,915.48
51101	Өмч: - торийн	1,356,036,915.48	1,356,036,915.48
512	Хуримтлагдсан үр дүн	918,567,974.01	1,002,581,354.19
51210	Өмнөх үеийн үр дүн	918,567,974.01	918,567,974.01
51220	Тайланг үеийн үр дүн	-	84,013,380.18
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,058,550.00	3,058,550.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,355,577,355.49	2,418,341,483.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,463,839,579.07	1,273,517,771.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	607,319,379.07	32,108,471.50
120	Нийтлэг татварын бус орлого	599,639,379.07	32,108,471.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	599,639,379.07	32,108,471.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,007,500.00	369,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		156,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	598,631,879.07	31,583,271.50
120009	Бусад орлого		
122	Тусламжийн орлого	7,680,000.00	-
122001	Хандив тусламж /дотоод/	7,680,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	856,520,200.00	1,241,409,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	695,748,700.00	1,049,275,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	695,748,700.00	1,049,275,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	160,771,500.00	192,133,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	160,771,500.00	192,133,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	854,646,152.67	1,189,504,391.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	854,646,152.67	1,189,504,391.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	819,380,301.22	1,154,980,853.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	487,352,791.97	707,216,917.00
210101	Үндсэн цалин	350,447,260.20	453,338,293.00
210102	Нэмэгдэл	116,506,911.77	232,569,886.00
210104	Урамшуулал	20,398,620.00	21,308,738.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,745,467.53	88,242,347.34
210201	Тэтгэврийн даатгал	42,705,801.93	60,387,155.76
210202	Тэтгэмжийн даатгал	4,873,004.48	7,085,574.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,871,786.05	3,542,787.60
210204	Ажилгүйдлийн даатгал	934,605.69	3,434,020.13
210205	Эрүүл мэндийн даатгал	9,360,269.38	13,792,809.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155,380,068.55	175,865,361.72
210301	Гэрэл, цахилгаан	9,248,568.55	10,949,764.72
210302	Түлш, халаалт	143,353,900.00	162,215,597.00
210303	Цэвэр, бохир ус	2,777,600.00	2,700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,177,199.56	9,861,830.00
210401	Бичиг хэрэг		316,500.00
210402	Тээвэр, шатахуун		1,131,600.00
210408	Бараа материал акталсны зардал	5,177,199.56	8,413,730.00
2105	Нормативт зардал	29,272,000.00	27,443,400.00
210502	Хоол, хүнс	29,272,000.00	27,443,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	12,900,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	12,900,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	1,810,000.00
210702	Дотоод албан томилолт		1,810,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,342,368.00	12,475,718.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,007,500.00	369,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,334,868.00	12,106,518.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,110,405.61	119,165,278.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,466,175.00	27,539,165.35
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,346,750.00	2,989,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	55,297,480.61	88,636,513.31
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	35,265,851.45	34,523,538.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	33,874,420.00	32,655,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	33,874,420.00	32,655,500.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,391,431.45	1,868,038.28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,391,431.45	1,868,038.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	609,193,426.40	84,013,380.18
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,831,256.53	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,831,256.53	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(1,831,256.53)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	607,362,169.87	84,013,380.18

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	857,527,700.00	1,241,934,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,007,500.00	525,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,007,500.00	525,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,007,500.00	525,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,007,500.00	369,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	156,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	856,520,200.00	1,241,409,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	695,748,700.00	1,049,275,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	695,748,700.00	1,049,275,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	160,771,500.00	192,133,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	160,771,500.00	192,133,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	799,101,108.36	1,136,283,076.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	799,101,108.36	1,136,283,076.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	768,297,486.91	1,098,862,837.93
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	487,352,791.97	707,340,932.00
210101	Үндсэн цалин	350,447,260.20	453,462,308.00
210102	Нэмэгдэл	116,506,911.77	232,569,886.00
210104	Урамшуулал	20,398,620.00	21,308,738.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,741,839.39	88,118,333.89
210201	Тэтгэврийн даатгал	42,702,173.79	60,263,142.31
210202	Тэтгэмжийн даатгал	4,873,004.48	7,085,574.46
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,871,786.05	3,542,787.60
210204	Ажилгүйдлийн даатгал	934,605.69	3,434,020.13
210205	Эрүүл мэндийн даатгал	9,360,269.38	13,792,809.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	155,380,068.55	175,265,361.72
210301	Гэрэл, цахилгаан	9,248,568.55	10,349,764.72
210302	Түлш, халаалт	143,353,900.00	162,215,597.00
210303	Цэвэр, бохир ус	2,777,600.00	2,700,000.00
2105	Нормативт зардал	26,732,000.00	30,072,900.00
210502	Хоол, хүнс	26,732,000.00	30,072,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,000.00	15,000,000.00
210604	Урсгал засвар	4,000,000.00	15,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,334,868.00	17,475,718.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		369,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,334,868.00	17,106,518.32
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,755,919.00	65,589,592.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,158,719.00	58,411,992.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,597,200.00	7,177,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,803,621.45	37,420,238.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,412,190.00	35,552,200.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	29,412,190.00	35,552,200.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,391,431.45	1,868,038.28
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,391,431.45	1,868,038.28
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	58,426,591.64	105,651,423.79
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	58,426,591.64	105,651,423.79
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		103,832,030.68
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	209,483,454.47

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,356,036,915.48	3,058,550.00	918,567,974.01	2,277,663,439.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,356,036,915.48	3,058,550.00	918,567,974.01	2,277,663,439.49
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	84,013,380.18	84,013,380.18
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,356,036,915.48	3,058,550.00	1,002,581,354.19	2,361,676,819.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,344,712,800.00	1,134,415,037.93	210,297,762.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,344,712,800.00	1,134,415,037.93	210,297,762.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,307,094,000.00	1,098,862,837.93	208,231,162.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	878,052,800.00	707,340,932.00	170,711,868.00
210101	Үндсэн цалин	561,550,000.00	453,462,308.00	108,087,692.00
210102	Нэмэгдэл	304,644,100.00	232,569,886.00	72,074,214.00
210104	Урамшуулал	11,858,700.00	21,308,738.00	(9,450,038.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	109,756,400.00	88,118,333.89	21,638,066.11
210201	Тэтгэврийн даатгал	74,634,500.00	60,263,142.31	14,371,357.69
210202	Тэтгэмжийн даатгал	8,780,500.00	7,085,574.46	1,694,925.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,390,200.00	3,542,787.60	847,412.40
210204	Ажилгүйдлийн даатгал	4,390,200.00	3,434,020.13	956,179.87
210205	Эрүүл мэндийн даатгал	17,561,000.00	13,792,809.39	3,768,190.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	177,133,400.00	175,265,361.72	1,868,038.28
210301	Гэрэл, цахилгаан	12,140,000.00	10,349,764.72	1,790,235.28
210302	Түлш, халаалт	162,215,800.00	162,215,597.00	203.00
210303	Цэвэр, бохир ус	2,777,600.00	2,700,000.00	77,600.00
2105	Нормативт зардал	39,244,000.00	30,072,900.00	9,171,100.00
210502	Хоол, хүнс	39,244,000.00	30,072,900.00	9,171,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	15,000,000.00	-
210604	Урсгал засвар	15,000,000.00	15,000,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,153,100.00	17,475,718.32	1,677,381.68
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	369,200.00	369,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,783,900.00	17,106,518.32	1,677,381.68
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,754,300.00	65,589,592.00	3,164,708.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	61,576,700.00	58,411,992.00	3,164,708.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,618,800.00	35,552,200.00	2,066,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	37,618,800.00	35,552,200.00	2,066,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,618,800.00	35,552,200.00	2,066,600.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,868,038.28	(1,868,038.28)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,344,712,800.00	1,241,934,500.00	102,778,300.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,049,275,900.00	1,049,275,900.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,049,275,900.00	1,049,275,900.00	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	192,133,400.00	192,133,400.00	-
132001	Орон нутгийн төсвөөс	192,133,400.00	192,133,400.00	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	103,303,500.00	525,200.00	102,778,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	369,200.00	369,200.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	156,000.00	(56,000.00)
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	102,834,300.00		102,834,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		103,832,030.68	(103,832,030.68)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		209,483,454.47	(209,483,454.47)

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа илрээгүй болно.

Аудитаар 1,471.0 мянган төгрөгийн илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Төлбөрийн акт

Байхгүй.

3.2 Албан шаардлага

Нягтлан бодогчид ЕБС-ын захирлын 2024 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн Б/22 тоот тушаалаар балансын урамшуулал 1471.0 мянган төгрөгийг улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан олгосон.

3.3 Зөвлөмж

Байхгүй.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Урамшуулал давхардуулан олгосон.	1	1,471.0			1	1,471.0						
Дүн	1	1,471.0			1	1,471.0						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган

төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 07

Дугаар 19-ХЭА-2025/023/НА-СТА-ТШЗ
17925043 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нягтлан бодогчийн ажлыг улирал бүр дүгнэж, ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон боловч Захирлын 2024 оны Б/22 тоот тушаалаар санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнүүлсэн гэх үндэслэлээр нягтлан бодогчид 1,471.0 мянган мянган төгрөгийн урамшууллыг цалингийн зардлаас давхардуулан олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна", Сангийн сайдын 2023 оны 211 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан "Урсгал зардлын ангиллын тайлбар" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урамшуулал давхардуулан олгодог зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цэнхэрмандал сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Отгондуламд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

"СТАНДАРТ ДҮГНЭЛТ АУДИТ"
ХХК-ИЙН АУДИТОР

Б.НАРАНЦЭЦЭГ

232540019